



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 10 сарын 09 өдөр

Дугаар 432

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас
балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Улаанбаатар дулааны сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн нийт 41,380,000.00 (дөчин нэгэн сая гурван зуун наян мянган) төгрөгийн балансын үнэ бүхий үндсэн хөрөнгийг хавсралтад заасан байгууллагад балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга З.Мэндсайхан, “Улаанбаатар дулааны сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Д.Бямба-Очир болон тогтоолд заасан байгууллагын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 4 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.


3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Ц.НЯМ-ОСОР


ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ГАВАА



0002275

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 2018 оны 10 дугаар сарын 09 ны өдрийн
 438 дугаар тогтоолын хавсралт



"Улаанбаатар дулааны сүлжээ" төрийн өмчит хувьцаат компанийн балансаас
 жагсаалтад дурдсан байгууллагын балансад шилжүүлэх хөрөнгө

Д/д	Автомашинь төрөл, зориулалт, улсын дугаар	Үйлдвэрлэсэн/ Ашиглалтад орсон он	Нийт үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)	Шилжүүлж авах байгууллага
1	"ЗИЛ-130", ачааны, 27-02 УБР, 20246092, 3459529	2001/2001	25,000,000.00	25,000,000.00	0	Дархан-Уул аймгийн Онцгой байдлын газарт
2	Путик	2000	1,380,000.00	1,380,000.00	0	Дархан-Уул аймгийн Онцгой байдлын газарт
3	УАЗ-31519, суудлын, УБЭ 49-48, 60544308	2006/2006	15,000,000.00	15,000,000.00	0	Дорнод аймгийн Онцгой байдлын газарт
			41,380,000.00 (дөчин нэгэн сая гурван зуун наян мянган)	41,380,000.00 (дөчин нэгэн сая гурван зуун наян мянган)		

НИЙТ ДҮН: